

**Боловсрол, соёл, урлагийн газрын 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2018.02.08

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Байгууллагын 2017 онд хийсэн ажлыг аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдэд тайлагнав.		
2	БСШУС-ын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэсийн төсвийн хоёр мэргэжилтэн, ТББ – ын төсөл хариуцсан мэргэжилтэн нар манай аймгийн 17 бага сургуульд “Бага боловсролын орчинг сайжруулах” төсөл хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан судалгаа хийж 3 хоног ажиллаж, цаашид хэрэгжүүлэх төслийн хүрээнд санал бодлоо солилцсон.		
3	“ЭЕШ-ын үр дүнг дээшлүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит түвшин тогтоох шалгалтыг аймгийн нийт ЕБС-ийн багш нараас 16 төрлийн хичээлээр, 12 дугаар ангийн сурагчдаас 9 төрлийн хичээлээр, “Эх хэл, монгол хэл, бага боловсролын чанарыг дээшлүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд 5 дугаар ангийн сурагчдаас монгол хэл, казах хэлний хичээлээр авахаар материалыг бэлтгэн сургуулиудад хүргүүлсэн. ЕБС-ийн багш, сурагчдаас шалгалт авч засаж, дүнг нэгтгэн аймгийн БСУГазарт хүргүүлэх ажил хийгдэж байна.	Шалгалтын дүнг нэгтгэн, дүн шинжилгээ хийх	
4	Орос хэлний хичээлийн улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг аймагт зохион байгуулж, нийт 32 орос хэлний багш, 9,12 дугаар ангийн 63 сурагч хамрагдаж, Дарын БДС – ийн багш С.Айжанар, тус сургуулийн 12 дугаар ангийн сурагч М. Нурсауле, Е.Ахмарал, 9 дүгээр ангийн сурагч Х.Еркебулан, 4 дүгээр БДС-ийн сурагч А.Лагыл нар улсын төрөлжсөн		

	олимпиадын 3 – ын даваанд оролцох эрхийн болзлыг хангасан болно.		
5	Өргөдөл, гомдлын мөрөөр 2 дугаар БДС-д шалгалт хийх тухай аймгийн Засаг даргын захирамжийн дагуу хоёр мэргэжилтэн тус сургуульд ажилласан.		
6	Өлгий сумын 11 дүгээр цэцэрлэгийн зарим эцэг, эхийн гаргасан өргөдөл гомдлын мөрөөр БСУГ-ын дарга ажиллаж, үйл ажиллагааг сайжруулах талаар үүрэг даалгавар өгсөн.		
7	“Номын анд-2018” 3 сарын аянг аймгийн нийтийн номын сантай хамтран Өлгий сумын ЕБС – ийн сурагчдын дунд зарлан зохион байгуулж байна.		
8	Аймгийн соёл, урлагийн байгууллагын 2017 оны статистик мэдээг /СУ1-15/ зохих маягтын дагуу нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.		